



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 5/103

Хэрлэн сум

**Б.Отгонзаяад ур чадварын
нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2, 3 дугаар хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээллийн ажилтан Батбаярын Отгонзаяад ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож олгосугай.

2.Ур чадварын нэмэгдлийг 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрөөс тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНТУЛГА